

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	13
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	13
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



УХААЛАГ ЗАСАГ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Ч.НУРГУЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 47/535
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ухаалаг засаг төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ухаалаг засаг төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төслийн удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төслийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүрэлдэхүүн хэсгийн нийт 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,397,496,412.97	3,060,680,258.16
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,397,496,412.97	3,060,680,258.16
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,397,496,412.97	3,060,680,258.16
31210	Төгрөг	7,050,667.50	37,416,598.73
31211	Төрийн сангийн харилцах	7,050,667.50	37,416,598.73
31220	Гадаад валют	2,390,445,745.47	3,023,263,659.43
31223	Арилжааны банк дахь харилцах	2,390,445,745.47	3,023,263,659.43
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	70,703,634.18	82,762,676.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,703,634.18	82,762,676.18
39200	Биет хөрөнгө	68,741,168.43	82,100,210.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,900,000.00	74,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,800,821.92)	(23,290,821.92)
39205	Машин тоног төхөөрөмж	27,343,600.00	55,781,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,781,136.00)	(27,671,756.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,041,690.00	13,841,690.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,962,163.65)	(11,460,501.65)
39300	Биет бус хөрөнгө	1,962,465.75	662,465.75
39301	Програм хангамж	6,500,000.00	6,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,537,534.25)	(5,837,534.25)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,468,200,047.15	3,143,442,934.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,889,735.47	2,353,750.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,889,735.47	2,353,750.00
41300	Өглөг	2,889,735.47	2,353,750.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	358,199.78	-
41360	Бусад өглөг	2,531,535.69	2,353,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,531,535.69	2,353,750.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,465,310,311.68	3,141,089,184.34
51	Засгийн газрын хувь оролцоо	2,465,310,311.68	3,141,089,184.34
51200	Хуримтлагдсан үр дүн	2,465,310,311.68	3,141,089,184.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,715,008,766.29	2,465,310,311.68
51220	Тайлант үеийн үр дүн	(249,698,454.61)	675,778,872.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,468,200,047.15	3,143,442,934.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,707,393,473.99	12,496,376,209.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,707,393,473.99	12,496,376,209.12
120	Нийтлэг татварын бус орлого	10,707,393,473.99	12,496,376,209.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,707,393,473.99	12,496,376,209.12
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,957,327.39	21,695,723.03
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,653,436,146.60	12,474,680,486.09
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,023,161,492.47	11,911,248,501.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,023,161,492.47	11,911,248,501.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,969,204,165.08	11,889,552,778.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	228,895,766.75
210101	Үндсэн цалин	-	228,895,766.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,232,900.23
210201	Тэтгэврийн даатгал	-	18,232,900.23
2104	Хангамж, бараа материалын зардал	13,196,080.07	13,533,196.50
210401	Бичиг хэрэг	1,251,554.54	878,271.99
210402	Тээвэр, шатахуун	3,399,550.00	3,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,544,975.53	7,387,734.51
210404	Ном, хэвлэл	-	1,967,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,940,120,809.04	11,610,711,956.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,940,120,809.04	11,610,711,956.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,887,275.97	18,178,958.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,887,275.97	18,178,958.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,957,327.39	21,695,723.03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,957,327.39	21,695,723.03
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	53,957,327.39	21,695,723.03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(315,768,018.48)	585,127,707.76
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	66,069,563.87	90,651,164.90
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	66,069,563.87	90,651,164.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(249,698,454.61)	675,778,872.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
/төгрөгөөр/			
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,335,835,033.84	5,859,205,222.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,335,835,033.84	5,859,205,222.16
120	Нийтлэг татварын бус орлого	13,335,835,033.84	5,859,205,222.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,335,835,033.84	5,859,205,222.16
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	53,957,327.39	21,695,723.03
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	10,653,436,146.60	5,837,509,499.13
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	2,628,441,559.85	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,004,408,184.74	5,256,434,541.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,004,408,184.74	5,256,434,541.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,950,450,857.35	5,234,738,818.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	231,427,302.45
210101	Үндсэн цалин	-	231,427,302.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	16,237,350.00
210201	Тэтгэврийн даатгал	-	16,237,350.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,196,080.07	13,533,196.50
210401	Бичиг хэрэг	1,251,554.54	878,271.99
210402	Тээвэр, шатахуун	3,399,550.00	3,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,632,620.53	7,387,734.51
210404	Ном, хэвлэл	3,912,355.00	1,967,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,937,254,777.28	4,973,540,969.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,937,254,777.28	4,973,540,969.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,957,327.39	21,695,723.03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,957,327.39	21,695,723.03
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	53,957,327.39	21,695,723.03
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,331,426,849.10	602,770,680.29
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	30,238,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	30,238,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	30,238,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	30,238,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(30,238,000.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	66,069,563.87	90,651,164.90
14	Бусад эх үүсвэр	66,069,563.87	90,651,164.90
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	66,069,563.87	90,651,164.90
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,397,496,412.97	663,183,845.19
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,397,496,412.97
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,397,496,412.97	3,060,680,258.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,715,008,766.29	2,715,008,766.29
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,715,008,766.29	2,715,008,766.29
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(249,698,454.61)	(249,698,454.61)
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,465,310,311.68	2,465,310,311.68
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,465,310,311.68	2,465,310,311.68
19	Тайлант үеийн үр дүн	-	-	675,778,872.66	675,778,872.66
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	3,141,089,184.34	3,141,089,184.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,920,310,800.00	11,902,147,805.80	18,162,994.20	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,920,310,800.00	11,902,147,805.80	18,162,994.20	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,920,310,800.00	11,902,147,805.80	18,162,994.20	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,624,900.00	231,427,302.45	2,197,597.55	99.0
210101	Үндсэн цалин	233,624,900.00	231,427,302.45	2,197,597.55	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,438,300.00	16,237,350.00	2,200,950.00	88.0
210201	Тэтгэврийн даатгал	18,438,300.00	16,237,350.00	2,200,950.00	88.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,690,800.00	13,533,196.50	3,157,603.50	81.0
210401	Бичиг хэрэг	2,078,100.00	878,271.99	1,199,828.01	42.3
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	3,300,000.00	700,000.00	82.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,636,600.00	7,387,734.51	248,865.49	96.7
210404	Ном, хэвлэл	2,976,100.00	1,967,190.00	1,008,910.00	66.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,651,556,800.00	11,640,949,956.85	10,606,843.15	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,651,556,800.00	11,640,949,956.85	10,606,843.15	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,920,310,800.00	12,474,680,486.09	(554,369,686.09)	104.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,920,310,800.00	12,474,680,486.09	(554,369,686.09)	104.6
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	11,920,310,800.00	12,474,680,486.09	(554,369,686.09)	104.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,397,496,412.97	(2,397,496,412.97)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,060,680,258.16	(3,060,680,258.16)	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ухаалаг засаг төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ч.Нургул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсөл хэрэгжүүлэх гарын авлагыг шинэчлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Грант Торнтон аудит” ХХК-ийн захирал Ерөнхий захирал, Удирдах партнер Б.Осоргарав, Чанарын хянагч Н.Эрдэнэцог, Гэрээт ажлын менежер Б.Дэлгэрмаа нар хянан удирдаж, аудитор Б.Эрдэнэбат туслах аудитор Э.Удвал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ухаалаг засаг төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2021 оны 02 сарын 5-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ухаалаг засаг төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр соёрхон баталсан. Ухаалаг засаг төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол Улсад мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгоход оршино.

Ухаалаг засаг төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийн оролцоог дэмжих;
- Төрийн мэдээллийн технологийн нэгдсэн тогтолцоог бий болгох;
- Төрийн өгөгдөл мэдээллийн нээлттэй орчныг бий болгох.

Ухаалаг засаг төсөл нь дараах онцлох ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвийн системийн болон техникийн бүрэн шинэчлэл хийж, иргэдийн санал хүсэлтийн өгөгдлийн сан бүрдүүлж, дүн шинжилгээ хийдэг болжээ.
- Үндэсний дата төв (Хур систем)-ийн серверийн өрөөний багтаамжийг 2 дахин, сүлжээний төхөөрөмжийн хүчин чадлыг 10 дахин нэмэгдүүлж, өргөтгөснөөр системд холбогдсон байгууллагын тоо 6 дахин өсч, эрүүл мэндийн даатгалын цэнхэр дэвтрийг халах, банк, татвар, нотариатын үйлчилгээнд лавлагааны цаасан баримтыг халах боломжийг бүрдүүлсэн байна.
- Улсын бүртгэлийн 30 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлснээс иргэний үнэмлэх, гадаад паспорт дахин авах үйлчилгээг e-Монголиа порталд нэгтгэсэн байна.

- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим системийг орон даяар нэвтрүүлж, цахим санг бүрэн бүрдүүлж, эд хөрөнгийн лавлагаа авах үйлчилгээний хугацааг эрс бууруулсан байна.
- Төрийн захиргааны байгууллагууд хэрэглэх боломжтой цахим хурлын шийдлийг ашиглан цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн ажил тасралтгүй явагдах боломжийг бүрдүүлсэн байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ухаалаг засаг төсөл санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, худалдан авалттай холбоотой зөрчилд 5 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмжийн дагуу тендерийн урилгыг цахимаар байршуулж, тендерийн баримт бичиг, үнэлгээний хорооны тайланг сайжруулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг Сангийн яам болон ЗГХЭГ-т хүргүүлж, худалдан авах ажиллагааны хавтаст бичгийг архивын нэгж болгон хадгалж, өгсөн зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Ухаалаг засаг төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төсөл нь гадаадын зээлээр хэрэгждэг тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зээлийн зарцуулалтад үндэслэн 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 11,911,248.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 119,112.5 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ухаалаг засаг төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 675,242.9 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,397,496.4	3,060,680.3	663,183.9
Үндсэн хөрөнгө	70,703.6	82,762.7	12,059.1
Нийт хөрөнгө	2,468,200.0	3,143,443.0	675,243.0
Өр төлбөр	2,889.7	2,353.8	(535.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,465,310.3	3,141,089.2	675,778.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,468,200.0	3,143,443.0	675,243.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 3,060,680.3 мянган төгрөг болж 663,183.9 мянган төгрөгөөр өссөн нь Дэлхийн банкнаас олгосон санхүүжилтийн хэмжээ өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны өртөг 151,023.3 мянган төгрөг болж 30,238.0 мянган төгрөгөөр өссөн нь 28,438.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,800.0 мянган төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,353.8 мянган төгрөг болж 535.9 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрөөс шалтгаалжээ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,141,089.2 мянган төгрөг болж 675,778.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Ухаалаг засаг төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,813,564.3 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан гадаадын эх үүсвэрээс санхүүжих орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 888,087.0 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 17,489,051.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 5,568,740.5 мянган төгрөгөөр бууруулж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 11,920,310.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 11,920,310.8 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Ухаалаг засаг төслийн 11,920,310.8 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 12,474,680.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 21,695.7 мянган төгрөг, нийт 12,496,376.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 11,902,147.8 мянган төгрөгийг зарцуулж 21,695.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,902,147.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 10,606.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2,208.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,201.0 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2,198.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 948.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 12,817.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь зөвлөхийн үйлчилгээний үлдэгдэл төлбөр хойшилсноос 10,606.8 мянган төгрөгөөр, цар тахлын хөл хорио, хязгаарлалтын улмаас 2020 онд сургалт хийгдээгүй тул бичиг хэрэгт 1,199.8 мянган төгрөг, хэвлэлд 1,008.9 төгрөг тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 19 төрлийн 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроон байршуулсан 12 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд байна. Мөн “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-ний мэдээлэлд тайлант хугацааны орлого, зарлагын гүйлгээний дүн, гүйлгээний утгыг оруулсан хэдий ч холбогдох шийдвэрийн хуулбаруудыг хавсаргаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн акт, албан шаардлага, хугацаатай зөвлөмж өгөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.694.356,5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,637,171.0 мянган төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайлан, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 57,185.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн харилцах дансаар дамжилгүй Дэлхийн банкнаас шууд хийгдсэн 6,637,171.0 мянган төгрөгийн төлбөрийг мөнгөн гүйлгээний тайланд тусгасныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.
Үүнд:

1. 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ажлын 10 хоног хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалттай нийцэхгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 57,185.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хөл хорионы улмаас хойшилж, бүрэн хэрэгжиж амжаагүй нийт 1,617,304.2 ам.долларын 9 гэрээт ажлын хэрэгжилт, хяналт шинжилгээ үнэлгээ нь төслийн үндсэн зорилгод нийцсэн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Батлагдсан төсөвтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2020 оны төсвийг зөвхөн урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж, батлуулсан боловч тайлант хугацаанд 30,238.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж ангилалд тайлагнасан байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан эдийн засгийн ангиллын хувьд буруу илэрхийлэгдэх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3 “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх” заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сангийн яамны зөвлөснөөр худалдан авсан хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж ангилалд бүртгэсэн.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд хувь зөвлөхтэй байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрт нийт 192,108.1 мянган төгрөг төлсөн боловч түүнд ногдуулах 26,947.5 мянган төгрөгийн НДШ-ийг суутгаагүй байна. Дэлхийн банк болон МУЗГ хооронд байгуулсан зээлийн гэрээ, уг гэрээний хавсралт болох Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон зөвлөхтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой заагаагүй байна.

2.2. Эрсдэл:

Хууль, журам хэрэгжихгүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.2 "Нийгмийн даатгалд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус, шашны болон бусад байгууллага, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;" заалтыг мөрдөж, Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон хувь хүнтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд Нийгмийн даатгалын шимтгэлийн талаар тодорхой тусгаж, ажиллахыг зөвлөж байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөхүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн байгууллагаас төлөх санхүүжилтийн эх үүсвэрийн тухай Ухаалаг засаг төслийн санхүүжилтийн хэлэлцээрт тусгаагүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/62/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Ухаалаг засаг төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	ТХН-ийн харилцах дансаар дамжилгүй Дэлхийн банкнаас шууд хийгдсэн 6,637,171.0 мянган төгрөгийн төлбөрийг ТХН нь мөнгөн гүйлгээний тайландаа тусгасан байна.	6,637,171.0	Залруулсан	Нягтлан бодогч	Ё.Оюун-Эрдэнэ
2	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ажлын 10 хоног хоцроосон.	-	Албан шаардлага хүргүүлсэн	Нягтлан бодогч	Ё.Оюун-Эрдэнэ
3	ТХН нь шилэн дансанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага хүргүүлсэн	Төслийн зохиулагч, Нягтлан бодогч	Ч.Нургул, Ё.Оюун-Эрдэнэ
4	Тайлант хугацаанд хувь зөвлөхтэй байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрт нийт 192,108.1 мянган төгрөг төлсөн боловч түүнд ногдуулах 26,947.5 мянган төгрөгийн НДШ-ийг суутгаагүй байна. Дэлхийн банк болон МУЗГ хооронд байгуулсан зээлийн гэрээ, уг гэрээний хавсралт болох Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон зөвлөхтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой заагаагүй байна.	26,947.5	Зөвлөмж өгсөн	Төслийн зохиулагч, Нягтлан бодогч	Ч.Нургул, Ё.Оюун-Эрдэнэ
5	ТХН нь 2020 оны төсвийг зөвхөн урсгал зардлын ангиллаар бэлтгэж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв төлөвлөгөөнд нэгтгүүлж, төлөвлөсөн эдийн засгийн ангиллын дагуу Сангийн яамнаас баталсан байна. Гэвч тайлант хугацаанд ТХН нь 30,238.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, төсвийн гүйцэтгэлийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж ангилалд бүртгэсэн байна	30,238.0	Зөвлөмж өгсөн	Төслийн зохиулагч, Нягтлан бодогч	Ч.Нургул, Ё.Оюун-Эрдэнэ
ДҮН		6,694,356.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 161/А0160056

Улаанбаатар хот

САГ-2021/62/СТА-ТХН
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ухаалаг засаг төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 19 төрлийн 149 мэдээллээс 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4.1 "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг төслийн зохицуулагч Ч.Нургул, санхүүгийн ажилтан Ё.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

А.ДАВААДОРЖ

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Б.ЭРДЭНЭБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 162/A0160056

Улаанбаатар хот

САГ-2021-62-СТА-ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ухаалаг засаг төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ухаалаг засаг төсөл нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ажлын 10 хоног хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд ирүүлж байх, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ухаалаг засаг төслийн зохицуулагч Ч.Нургул, санхүүгийн ажилтан Ё.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
ГРАНТ ТӨРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

А.ДАВААДОРЖ

Б.ЭРДЭНЭБАТ

[illegible]